



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 05 сарын 19 өдөр

Дугаар 276

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 10 нэрийн нийт 131,948,600.00 (нэг зуун гучин нэгэн сая есөн зуун дөчин найман мянга зургаан зуун) төгрөгийн балансын үнэ, 54,971,054.14 (тавин дөрвөн сая есөн зуун далан нэгэн мянга тавин дөрвөн төгрөг арван дөрвөн мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу цаашид ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоож “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанид балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Д.Баярсайхан нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2 Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн, санхүүгийн тайланд тусгах;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4. Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.НАРАНГЭРЭЛ



300481

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 12 дугаар сарын 19 ны өдрийн
876 дугаар тогтоолын хавсралт

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРААС "УЛААНБААТАР ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ" ТӨРИЙН ӨМЧИТ
ХУВЬЦААТ КОМПАНИД БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглах хугацаа	Ашиглалтад орсон огноо	Тоо хэмжээ	Балансын нийт үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг	Шинэчлэн тогтоосон үнэ	Цаашид ашиглах хугацаа
					(төгрөг)				(жил)
1	КТПН 10/0.4 КВ	12	12/30/2012	1	22,000,000.00	12,833,333.52	9,166,666.48		
2	Тоолуур электрон 40А	5	12/30/2012	174	14,651,400.00	14,651,400.00	-	1,465,140.00	1
3	Тоолуурын хайрцаг	5	12/30/2012	18	1,485,000.00	1,485,000.00	-	148,500.00	1
4	Шон төмөр бетон	20	9/1/2012	52	14,185,600.00	5,319,600.30	8,865,999.70		
5	Нам хүчний самбар 0.04 КВ	6	9/1/2012	1	825,000.00	825,000.00	-	82,500.00	
6	Төмөр бетон тулгуур ТБШ12	15	9/1/2012	8	2,772,000.00	1,386,000.00	1,386,000.00		
7	Хуурай салгуур РВ-10/400	6	9/1/2012	1	935,000.00	935,000.00	-	93,500.00	1
8	Хоолой АВС Ф56	6	9/1/2012	31	682,000.00	682,000.00	-	68,200.00	1
9	Автомат 3 фазын	6	9/1/2012	28	2,464,000.00	2,464,000.00	-	246,400.00	1
10	Зуслан дахь бага оврын цахилгаан станц-Найрамдал	40	12/30/2011	1	71,948,600.00	14,389,720.32	57,558,879.68		
НИЙТ ДҮН					131,948,600.00	54,971,054.14	76,977,545.86	2,104,240.00	-
					(нэг зуун гучин нэгэн сая есөн зуун дөчин найман мянга зургаан зуун)	(тавин дөрвөн сая есөн зуун далан нэгэн мянга тавин дөрвөн төгрөг арван дөрвөн мөнгө)	(далан зургаан сая есөн зуун далан долоон мянга таван зуун дөчин таван төгрөг наян зургаан мөнгө)	(хоёр сая нэг зуун дөрвөн мянга хоёр зуун дөчин)	